

Хоршоо, ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Гэрэлт-Од Мөнхтуяа

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1		2	3	4	5	6	7
1.1. "Хоршоодыг хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III"-ийг орон нутагт хэрэгжүүлнэ.							
1	Хоршоодын туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан.	-	Аймгийн Засаг даргын 2023 оны 12 сарын 20 ны өдрийн А/999 дүгээр захирамжаар орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, брэнд бий болгох зорилгоор үйлдвэрлэгчдийг Булган, Хөвсгөл аймгуудын жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаатай танилцуулан харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулан ажиллав. Туршлага судлах аялалд нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, Булган, Хөвсгөл аймгийн 12 үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцав. Хавсралт: 1 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар	100%

2	Хоршоодыг чадавжуулах сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	2 удаагийн сургалт зохион байгуулсан.	1 удаагийн сургалт зохион байгуулсан байна.	1. Хүнс, хөдөө аж ахуйн газраас сумдын ЗДТГазар, Best хөтөлбөртэй хамтран Сангийн сайдын 2022 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан "Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам", "Санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх заавар"-ыг ашиглах, санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 10 хоршооны дарга, нягтлан бодогч нийт 25 хүнийг хамруулан мэдлэг олгов. Үүний үр дүнд хоршоод 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг журмын дагуу үнэн зөв гаргасан. 2. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Санхүүжилттэй Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй Best хөтөлбөр, сумдын Засаг даргын Тамгын газар, Болор үйлсийн үндэс ТББ-тай хамтран дээр дурдсан саад бэрхшээлийг даван туулж, хоршоод урагш хөгжихийн тулд сайн засаглал, санхүүжилт авах, өрсөлдөх чадавх бэхжүүлэх сургалт, зөвлөгөө авах, бодит хэрэгжихүйц төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний дагуу 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 145	5-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар	100%
---	--	---	---------------------------------------	---	--	--------------------------------------	------

						хоршооны гишүүнийг хамруулсаны үр дүнд "Хоршоо хөгжүүлэх сан"-аас 2024 онд Баян-Өндөр сумын мал аж ахуйн чиглэлийн Арга билиг арвин сүрэг хоршоо 100 сая, Лууснын дагина хоршоо 50 сая, Жаргалант сумын газар тариалангийн борлуулалтын чиглэлийн БЛГЯ хоршоо 100 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.		
3	Хоршоодын зөвлөгөөн байгуулах	бүсийн зохион	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	-	Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий бүсийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах - "Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хууль, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий Хойд бүсийн нээлтийн арга хэмжээ 2024 оны 05 дугаар сарын 06-нд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Спорт цогцолборт зохион байгуулагдав. Тус нээлтийн арга хэмжээнд ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нар болон Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголбанк, Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын холбогдох албан	3-р сар, 4-р сар, 5-р сар	100%

					тушаалтнууд, Орхон, Хөвсгөл, Булган аймгийн нийт 1402 төлөөлөгч оролцож “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий зорилго, хоршоонд нэгдэхийн ач холбогдол, хоршоо байгуулах, бүртгүүлэх, хэрхэн элсэх талаар зөвлөмж, хоршооны сайн туршлагуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан. Хойд бүсийн арга хэмжээг зохион байгуулахаар ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулсан. Хавсралт: 1 файл		
4	Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооноос зохион байгуулах Улсын зөвлөгөөнд хоршоодыг оролцуулах	Хоршоодын тоо	Амйгийн хөдө аж ахуйн хоршоологчдын холбооны 4 гишүүн хоршооны 10 төлөөлөл оролцсон.	Улсын зөвлөгөөнд хоршоодыг оролцуулсан байна.	Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо гишүүн хоршоодоо чадавхжуулах, хоршоод хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулдаг уламжлалттай. Энэ удаагийн зөвлөгөөнийг Хэнтий аймгийн Чингис хотноо 2024 оны 08-р сарын 04-07-ны өдрүүдэд “Хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөн”, NAMAC CUP спортын бага наадам зохион байгуулагдсан. Орхон аймгаас Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2 мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны 5 гишүүн хоршоодын 12 хүн нийт 14	8-р сар, 9-р сар	100%

					хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцсон.		
					Хавсралт: 1 файл		
5	Салбарын мэдээллийн сангийн баяжилтийг тогтмол хийх	Хоршоодын тоо	Орхон аймагт 61 хоршоо Улсын бүртгэлд бүртгэлтэй байна.	Хоршоодын шинэчилсэн бүртгэл хийгдсэн байна.	Орхон аймгийн хэмжээнд 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өмчийн байдлаар Улсын бүртгэлд 69 хоршоо бүртгэлтэй байна. Үүнээс: "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хөдөө аж ахуйн чиглэлийн 39 хоршоо шинээр байгуулагдсанаас 40 хоршооны 151 малчин өрх хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна.	6-р сар, 12-р сар	100%
1.2. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.							
6	Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний, хамруулсан хүний тоо	3 сургалт зохион байгуулж, 110 иргэн хамрагдсан.	-	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн холбоодтой хамтран ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 190 хүнийг хамруулсан. Үүнд: 1. "ДЭЛХИЙН" хэмжээний артист бэлтгэн гаргах, өөртөө ажлын байр бий болгох, хувь хүний ур чадварыг хөгжүүлэх зорилгоор Гоёлын шивээсний техникийн сургалтыг явуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификатыг 10 хүнд олгосон. 2. Үс тайралтын төрөл, Үс будалтын төрөл, Үндсэн будгийн ерөнхий онол болон техникийг зааж модель дээр хийж үзүүлсэн.	1-р сар, 4-р сар, 5-р сар	100%

					Сургалтад 50 гаруй үсчид хамрагдсан. 3.Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан “Хайр нэмье” эмэгтэйчүүдийн өдөрлөгт 100 эмэгтэйг хамруулсан. 4.“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд “Гепатитын вирусийн халдварын тандалт, урьдчилан сэргийлэлт” бэхжүүлэх нь” сэдэвт чадавхжуулах сургалтыг Орхон аймгийн үсчин, гоо сайханч, хумс засалч, гоёлын шивээсний үйлчилгээ эрхлэгч 30 хүнийг хамруулсан.		
7	Явуулын ахуйн үйлчилгээг байгуулах зохион	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан	-	1.Жаргалант сумын иргэдэд ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээг зах зээлийн үнээс хямд, нэг цэгээс хүрч үйлчлэх, иргэдийн зардлыг хэмнэх, үйлчилгээ эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын ахуйн үйлчилгээг” 2024 оны 10-р сарын 25-ны өдөр Жаргалант сумын Соёлын төвд зохион байгуулж, 185 иргэнд 14 чиглэлийн үйлчилгээг үзүүлэн 1.8 сая төгрөгийн орлоготой ажилласан. 2. Урлахуйн жигүүр ТББ-тай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр “Энэрэл төв” асрамжийн газрын 18 хүүхдийн үсийг үнэ	5-р сар, 6-р сар	100%

					төлбөргүй засаж, үйлчилгээ үзүүлсэн.		
8	Үсчин, гоо сайханчдын бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан	-	Монголын Үсчин гоо, засалчдын үндэсний холбоотой хамтран “Төв болон хангайн бүс-2024” үсчин, гоо сайхан, хумс засалч дизайн урлалын мэргэжлийн аварга шалгаруулах бүсийн тэмцээнийг Орхон аймагт зохион байгуулсан. Тэмцээнд 6 аймгийн 100 гаруй төлөөлөл оролцсоноос Орхон аймгийн Үсчин, гоо засалчдын холбоо нь тус тэмцээнд 13 төрөлд 19 медаль /алт 8, мөнгө 6, хүрэл 5/ хүртэж “Шилдэг аймаг”-аар шалгарсан.	4-р сар, 5-р сар	100%
9	Ахун үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийг хөнгөлөлттэй хамруулах зээлд	Зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	4 иргэнд 78 сая төгрөг олгогдсон байна.	Ахун үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.	Ахуйн үйлчилгээний салбарын ШАН авто ланд ХХК нь авто машин, засвар, угаалга, гагнуур, дугуйн засварын цогц үйлчилгээг нэг доороос иргэдэд үйлчлэх зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 100 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
10	Ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг тохирлын үнэлгээнд хамруулах	Тохирлын гэрчилгээ олгосон иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Стандартын шаардлага хангасан 3 аж ахуйн нэгжид тохирлын гэрчилгээ олгосон.	Стандартын шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжид тохирлын гэрчилгээ олгосон байна.	Аймгийн хэмжээнд үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхлэгчдэд “Үс засах үйлчилгээ” MNS 5160:2020, “Гоёлын гоо заслын үйлчилгээ” MNS 5567:2006, “Хумс заслын үйлчилгээ” MNS 6843:2020 стандартын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 10 салони төлөөлөл 24 хүн хамрагдсан. Үүний үр дүнд стандарт	9-р сар, 10-р сар, 11-р сар	100%

189

					хэмжилзүйн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу саун, чийрэгжүүлэх төв, үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхэлж байгаа 5 иргэн, аж ахуйн нэгжийн 8 үйлчилгээний үйл ажиллагаатай танилцаж, "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020, "Гоёлын гоо заслын үйлчилгээ" MNS 6843:2006, "Хумс заслын үйлчилгээ" MNS 6843:2020, "Сауны үйлчилгээ" MNS 5164:2010 стандартын үзүүлэлтийн дагуу бодитойгоор үнэлж, дүгнэн мэргэжлийн зөвлөмж туслалцаа үзүүлэн стандартын шаардлага хангасан сауны үйлчилгээ эрхэлдэг Цацал, Дэнж, Чарминг, үсчин, гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Марал", "Shine", "Charming", "Нэмэх гоёл" "Чамин" зэрэг нийт 8 үйлчилгээний газарт 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон.		
11	Ахуйн үйлчилгээний ажилтны мэргэжил, ур чадвар олгох үе шаттай сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	1 удаагийн сургалтад 80 үсчин, гоо сайханчид хамрагдсан.	-	"Алтан гар" МҮГЗМ холбоо болон Intercharm Distribution /Fanola brand/, Орхон аймгийн ҮГЗХолбоотой хамтран үсчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 3 төрлөөр сургалтыг зохион байгуулагдсан. Сургалтад 50 гаруй үсчид хамрагдсан. Үс тайралтын төрөл : Asian layers style Үс будалтын төрөл : airtouch balayage with faceflaming Үндсэн будгийн	1-р сар, 2-р сар	100%

					ерөнхий онол болон техник 3 төрлөөр 2024 оны 05/28-ны өдөр 09:00-17:00 цагийн хооронд зохион байгуулагдсан. Сургалтыг "Алтан гар" МҮГЗХолбооны Н.Алтаншагай, О.БалжиннямС.Мөнхнасан, А.Хулан нар Модель дээр үс будалт тайралтын техник хийж үзүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар "Монголд дахь гоёлын шивээс нүүр будалтын холбоо", Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран "ДЭЛХИЙН" хэмжээний артист бэлтгэн гаргах, өөртөө ажлын байр бий болгох, хувь хүний ур чадварыг хөгжүүлэх зорилгоор Гоёлын шивээсний сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад хамрагдахаар 35 хүн бүртгүүлснээс сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай явуулж, эхний 10 хүнийг шалгаруулсан. Шалгарсан 10 хүнд 2 өдрийн Шивээсний техникийн сургалтыг явуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат олгосон.		
12	Ахуйн үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн дунд	Зохион байгуулсан арга	-	-	Ахуйн үйлчилгээний салбарт бизнес эрхлэгчдийг бүтээгдэхүүнийг иргэдэд таниулах, сурталчлах зорилгоор	6-р сар, 7-р сар	100%

үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	хэмжээний тоо				Амрын талбайд үзэсгэлэн худалдаа, загварын үзүүлбэрийг зохион байгуулсан. Тус үзэсгэлэн худалдаанд үндэсний хувцас үйлдвэрлэгчид, эсгий гар урлалын бүтээгдэхүүн, эрүүл мэндийн цай үйлдвэрлэл, шүрэн эдлэл, арьсан эдлэл, төмөр хийц, уран дархан мужаан, эко саван үйлдвэрлэл зэрэг чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгч өрхийн болон жижиг дунд бизнес эрхэлдэг 40 гаруй иргэн, аж ахуй нэгжийг хамруулж нийт 37.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин бараа, бүтээгдэхүүнийг сурталчилах, олон нийтэд таниулах зорилгоор “Хойд бүсийн түншлэл-2024” үзэсгэлэн худалдаа, Гар урлаачдын “Уран гар-2024” бүтээлийн уралдаан зэрэг нэгдсэн арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 29 ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Хангарди палас”-т амжилттай зохион байгууллаа. Тус нэгдсэн арга хэмжээнд Орхон, Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нийт 150 орчим үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрлэсэн, урласан 978 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 89.0 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн байна. Үзэсгэлэн худалдаанд оролцогч		

					Орхон, Хөвсгөл, Булган аймгийн 82 үйлдвэрлэгчийн бараа, бүтээгдэхүүний 8 номинацид шалгаруулалтыг хийж 9 шагнал олгон урамшуулав.		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
13	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх				ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг сараар гарган тайлагнаж байна. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
14	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг				Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Салбарын хууль тогтоомжийг судалж мэдлэг чадвараа дээшлүүлэх	Шинээр гарсан салбарын хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах	-	Салбарын хууль тогтоомжийг судалж мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж 2024-09-01 өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийг сурталчилан таниулах сургалтыг ХХААГ, Хүүхэд, гэр бүл хөгжлийн газар, Байгаль орчны газар хамтран зохион байгуулсан сургалтад хамрагдсан. "Уламжлалт	5-р сар, 6-р сар, 11-р сар, 12-р сар	100%

149

					мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024-04-27-нд Дотоод хэргийн Их сургууль дээр зохион байгуулагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий багийн гишүүн бэлтгэх сургалтад аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга, мэргэжилтэн, ХХААГ-ын мэргэжилтэн, Баян-Өндөр, Жаргалант сумын мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн хоршоологчдийн холбооны дарга нар хамрагдсан. “ШИНЭ ХОРШОО” хөдөлгөөнийг малчдад таниулан сурталчлах багийн гишүүдийн сургалт Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Тус сургалтад Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХэлтсийн хоршоо хариуцсан мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын хоршоо хариуцсан мэргэжилтэн, сумдын ЗДТГ-ын хоршоо хариуцсан мэргэжилтэн нар хамрагдсан. Сангийн сайдын 2022 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан “Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам”, “Санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх заавар”-ыг судалж мэдлэгээ дээшлүүлсэн.		
2	Ур чадвар дээшлүүлэх сургалт, арга	Сургалт, арга хэмжээнд оролцох	4 удаагийн сургалтад хамрагдсан байна.	1-ээс доошгүй сургалтад хамрагдаж, мэргэжил, ур	Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Мнгол	5-р сар, 6-р сар, 11-р сар, 12-р сар	100%

хэмжээнд хамрагдах		чадвараа дээшлүүлсэн байна.	бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хүрээнд 2025 оны 01-р сарын 01-нээс эхлэн төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах тухай Монгол хэлний хуулийг дагаж мөрдөхөд бэлэн эсэхийг үнэлэх зорилгоор "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа II"-г зохион байгуулах цахим сургалтад хамрагдсан. УБ хотоос Байгууллагын сургалтын лаб ТББ ын сургалтын хөтөлбөрийн зөвлөх чиглүүлэгч багш Г.Оюунгэрэл ирж Байгууллагын соёл дахь ажилчдын оролцоо сэдэвт багц сургалтад хамрагдсан. Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчлан таниулах сургалтад хамрагдсан. Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагын хэрэгжилт, үр дүн, сайжруулах арга зам" сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт оролцсон. 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 7:4:10 сургалт "Төрийн албан хаагчийн ёс зүй" цахим сургалтад хамрагдсан.	
-----------------------	--	-----------------------------------	---	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хоршоо, ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Гэрэлт-Од Мөнхтуяа /.....*Г. Мөнхтуяа*...../
Огноо:*2024.12.05*.....